

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ**  
**ГАЗРЫН 2018 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**  
 /2018.08.26 - 2018.09.25/

2018 оны 09 дугаар сарын 25

Замын-Үүд сум

№	Бүтээгдэхүүний нэр	Биелэлт
1	2	3
<b>Нэг. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр</b>		
1	Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулна.	Хууль тогтоомж зөрчсөн БНХАУ-ын 14 иргэнд зөрчлийн тухай хуулийн 16.2.1.4-д заасны дагуу 1,400.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, ГИЭЗБТх-ийн 37.1.7 дугаар зүйл болон Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан Гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журамын 3.7 дахь заалтад заасны дагуу МУ-д 3 жилийн хугацаанд дахин нэвтрэх эрхгүйгээр албадан гаргаж ажилласан болно.
2	Монгол Улсад байх, буцах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй, ирсэн зорилгоосоо өөр төрөл ангиллын визтэй зорчиж буй гадаадын иргэнийг хилээр нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авч, буцааж буй үндэслэлийг нарийн тогтоож материал бүрдүүлэн ажиллах	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1.6, Монгол улсад байх, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй 1 орны 7 иргэнийг улсын хилээр оруулалгүй буцаан ажилласан.
3	Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэдийн зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллана.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн БНХАУ-ын 45 иргэнийг 3.370,0 мянган төгрөг, үүнээс 5 аж ахуйн нэгж байгууллагын 15 иргэнд 884,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

1	2	3
4	Хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулах	Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус 1 удаагийн хяналт шалгалтыг Замын-Үүдийн Тагнуулын байгууллагатай хамтран зохион байгуулж 1 аж ахуйн нэгж байгууллагын 18 гадаадын иргэн, төлөвлөгөөт хяналт шалгалтаар 12 орны 304 гадаадын иргэн нийт 322 гадаадын иргэний паспорт паспортыг орлох баримт бичигт үзлэг шалгалт хийсэн. Шалгалтаар Хууль бусаар хөдөлмөр эрхлэж байсан БНХАУ-ын 14 иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан.
5	Замын-Үүд авто зам, төмөр замын боомтоор зорчиж байгаа гадаадын иргэдэд орох, гарах-орох, дамжин өнгөрөх виз олгох	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолыг тус тус үндэслэн виз олгохыг хүссэн 9 орны 78 иргэнд зохих зориулалт ангиллын визийг олгож, визийн хураамж болох 5,032.200 төгрөг, визийн үнэ болох 412,200 төгрөгийг Төрийн сангийн зохих дансанд нь төвлөрүүлэн ажилласан.
6	Виз, түр ирэгчийн бүртгэл, хасалт хийлгэх талаар гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийг шийдвэрлэн, бүртгэл хөтөлж, мэдээллийн санд баяжилт хийх	ХБНБразил Улсын-1, БНФУ-ын 1, ИБУИНВУ-ын-1, БНХАУ- 47, Нидерландийн Вант Улсын-1 иргэн нийт 52 иргэнийг түр ирэгчээр бүртгэн, бүртгэлийн хураамж болох 103,000 төгрөгийг зохих дансанд тушааж ажилласан. Оршин суух зөвшөөрөлд уригчийн хүсэлтээр хасалт хийж, ОСЗ хураалгасан БНХАУ-ын 28 иргэнд хасалт хийж Монгол Улсаас гаргасан болно.
<b>Хоёр. Захиргаа, удирдлага, хүний нөөцийн чиглэлээр</b>		
7	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх, санал хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас хайрцаг/ дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Тайлант хугацаанд хамтран ажиллагч байгууллагуудын дунд” Санал хүсэлтийн дэвтэр “ аялуулж, байгууллага болон албан хаагч нарын сахилга хариуцлага, ес зүйн , харилцаа цаашид хэрэгжүүлэн ажиллах санал хүсэлтийн талаар мэдээлэл солилцох ажлыг хэрэгжүүлж байна.
<b>Гурав. Санхүүгийн чиглэлээр</b>		

1	2	3
10	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах	Тайлант хугацаанд батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 37,746.1 мянган төгрөгийн санхүүжилт орсноор 55,359.0 мянган төгрөгний зарлага гаргасан. Үүнээс цалин хөлс 40,122.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 5,405.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 3,615.5 мянган төгрөгийг зарцуулан ажилласан.
11	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган харилцах дансаар хийгдсэн 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ болон бусад мэдээллийг хуулийн хугацаанд нь шилэн дансны сайтад шивж байршуулсан. Мөн 08 дугаар сарын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тайланг 2018 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.
12	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бусад тайланг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах	Төсвийн гүйцэтгэлийн 08 дугаар сарын мэдээ болон үнэт цаасны тайланг 2018 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Замын-Үүд төрийн сангаар хянуулан Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Дорноговь аймгийн Төрийн аудитын газарт 2017 оны 02,09,12 сар, 2018 оны 01,06 сарын касс харилцах, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, 2017 оны төсвийн батлагдсан төсөв, 2017 оны санхүүгийн тайлан шалгуулсан болно.